



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗАР



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024 он


**АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024.12. 16

Д/Д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1 Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а)байгууллагын албан ёсны цахим хуудас; b) сошиал сувгууд; c) дотоод сүлжээ; d) хэвлэл мэдээллийн хэрэгсэл, e) мэдээлэл сурталчилгаан самбар, лед дэлгэц f) бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх	Тус газар нь 9001:2015 олон улсын чанарын менежментийн стандартын хүрээнд байгууллагынхаа ЭРХЭМ ЗОРИЛГО, ХЭТИЙН ЗОРИЛГО, ЭРХЭМЛЭХ ҮНЭ ЦЭНЭ, ЧАНАРЫН БОДЛОГО, ЧАНАРЫН ЗОРИЛТЫГ тодорхойлж, шилдэг мэргэшсэн, үнэнч ёс зүйтэй, хамтын ажиллагаа түншлэлийг дэмжигч, эелдэг тусч, эрч хүчтэй, бүтээлч санаачлагатай хамт олон байхаа илэрхийлж байгууллагынхаа үйл ажиллагааг ил тод мэдээллэн ажиллаж байна. Ил тод байдлын мэдээллийг байгууллагын цахим хуудас http://daatgal.ar.gov.mn/ , нийгмийн даатгалын албан ёсны page хуудас, байгууллагын мэдээллийн самбар, www.gap.mof.gov.mn сайтад тус тус ил тод мэдээллэн ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн контент, зурагт хуудас, нугалбар зэрэг мэдээллийг байршуулан албан хаагч нар болон олон нийтэд хүргэн сурталчлан танилцуулахын зэрэгцээ газрын цахим хуудас болох arhangai.ndaatgal.mn сайтад Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, нийтлэл, зурагт хуудас, авлигын хор уршиг, сургалтын талаарх мэдээллүүдийг 18 удаа хуваалцаж, 92 удаагийн лайк дарж, 989 гаруй хандалт авсан байна. https://arkhangai.ndaatgal.mn/ , - Албан ёсны утас: 75079000, 70332659

		
1.2 Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээ зохион байгуулах;	2024 онд тус газар нь Тариат, Хашаат сумдад Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, 2024-2029 оны хооронд тэтгэвэр тогтоолгох иргэдэд зөвлөн туслах “Явуулын үйлчилгээг” хүргэн давхардсан тоогоор 410 гаруй иргэний материалыг хүлээн авч зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаад байна. Зөвлөгөө мэдээлэл авсан 24 иргэнээс үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авлаа. Судалгаанд 20-29 насны 4, 30-39 насны 7, 40-49 насны 3, 50-59 насны 10 хамрагдсан. 1. Ажилтны харилцаа хандлагад сэтгэл ханамжтай, үйл ажиллагааны талаарх мэдээлэл ил тод байдаг уу гэсэн асуултанд мэдэхгүй-7, үгүй-2, 2. Бэлэг хандив өгч байсан уу гэсэн асуултанд үгүй-24, 3. Авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх вэ гэсэн асуултанд а. Цахим үйлчилгээтэй болсон тул авлига байхгүй б. Мэргэжлийн чадварлаг ажилтантай байх, ил тод байх, үнэнч шударга байх.	

в. Харилцагчтайгаа тулж харилцах гэж 3 хүн хариулсан бусад нь огт юм бичээгүй байна.




1.3 Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах;

- Өөрийн байгууллагын пэйж хуудас болон харилцагч иргэд, даатгуулагчдад Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээллэн сурталчлах 110 утасны дугаарыг оруулсан зурагт хуудсыг харагдахуйц газар байршуулан сурталчлан ажиллаж байна.

			 
		1.4 Өөрсдийн үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх	Тус газрын иргэдэд үйлчлэх хэсэгт “Авлигыг мэдээл 110 ” утасны брошур хэвлэмэл хуудсыг байцаагч бүрийн цонхонд иргэдэд ил тод харагдахуйцаар байршуулсан. Мөн сошиал цахим хуудас, болон мэдээллийн самбартаа авлигын эрсдэлээс ангид байлгахад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент, постер зурагт хуудсыг байнга шинэчлэн байршуулж ,түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах ажлыг тогтмол хийж байна. “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” хэвлэмэл хуудсыг 1-2 давхарт байрлах мэдээлэх самбарт байршуулсан .

			
2	Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх	2.1 Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх;	-Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтыг ханган ажиллаж байна. Тус газар нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан 68 төрлийн 98 мэдээллээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах 236 мэдээллийг arhangai.ndaatgal.mn сайтад цахим хэлбэрээр мөн байгууллагын мэдээллийн самбарт байршуулах 12 төрлийн мэдээ мэдээллийг ажил олгогч даатгуулагч иргэдэд нээлттэй байршуулан ажиллалаа. Мөн нийгмийн даатгалын байгууллагын зүгээс иргэд, даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж авагч, ажил олгогч нарт зориулан хүргэж буй 34 төрлийн төрийн үйлчилгээг байцаагч ажилтнууд хуулийн хүрээнд нээлттэй, хүнд сурталгүй, чирэгдэлгүй, хугацаанд нь хүргэн ажиллаж байна. -Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр сул орон тооны мэдээллийг тухай бүр цахим хуудас болон Ил тод байдлын самбарт байршуулж, нээлттэйгээр сонгон шалгаруулалт хийж, 2024 оны 12 дүгээр сарын байдлаар 6 ажлын байр зарлаж, шинэ ажилтанг сонгон шалгаруулж ажилд нь тус тус томилсон байна. -Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/20 тоот тушаалыг хяналтандаа авч, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон мэдээллийн сайтад Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, сангийн болон үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг батлагдсан маягтын дагуу

		сар, улирал бүр мэдээг НДСан тус бүрээр нь гаргаж хуулийн хугацаанд нь тогтмол мэдээллэж ажилласан.  	сар, улирал бүр мэдээг НДСан тус бүрээр нь гаргаж хуулийн хугацаанд нь тогтмол мэдээллэж ажилласан.
	2.2 Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.	ЭММТЗ-өөс 2024 оны 5 сарын 24-ний өдөр “Авлигын шалтгаан нөхцөл, хор хөнөөл, гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт ZOOM сургалтыг зохион байгуулсан. ZOOM сургалтанд ЭММЗ, Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн эмч зэрэг нийтдээ 32 эмч, ажилтан хамрагдсан.  	ЭММТЗ-өөс 2024 оны 5 сарын 24-ний өдөр “Авлигын шалтгаан нөхцөл, хор хөнөөл, гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт ZOOM сургалтыг зохион байгуулсан. ZOOM сургалтанд ЭММЗ, Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн эмч зэрэг нийтдээ 32 эмч, ажилтан хамрагдсан.

		2.3 Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах	-Тус газар нь 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн саналд Нийгмийн даатгалын газрын барилгын конторын өргөтгөлийн барилгын зураг, төсөв өртөгийг төлөвлөж, төлөвлөлтийн мэдээллийг https://pimis.publicinvestment.gov.mn/#/login цахим сайтад ил тод мэдээллийг оруулсан. Төлөвлөлтийн хэрэгжилтийн биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт 2024 оны 1/446 тоот албан бичгээр хүргүүлээд байна./ -Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, сангийн болон үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг батлагдсан маягтын дагуу сар, улирал бүр мэдээг НДСан тус бүрээр нь гаргаж хуулийн хугацаанд нь тогтмол мэдээллэж ажилласан. Үүнд: НДС, НДС-ийн үйл ажиллагаатай холбоотой /Бусад мэдээлэл -134, худалдан авалт -48, төсвийн гүйцэтгэлийн -122/ мэдээллийг тайлагнасан байна.
		2.4 Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших	-Газрын даргын 2024 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн А/01 тоот тушаалаар байгууллагын “Ёс зүйн дэд хороо”-г шинэчлэн байгуулан ажиллаж байна. Газрын албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар танхимын сургалт 1 удаа, Төрийн албаны Архангай аймаг дахь салбар зөвлөлтэй хамтран шинээр томилогдсон байцаагч ажилчдыг чадавхижуулах цахим сургалтыг 1 удаа “ Төрийн албан хаагчийн ёс зүй ” сэдвээр зохион байгуулж газар сумдын нийт 35 байцаагч ажилчид хамрагдлаа. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай МУЗГ-ын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 тоот тогтоолыг албан хаагч нарт танилцах хуудсаар танилцуулж мэдээллээр ханган ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн байдлаар ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно. Ёс зүйн талаарх хууль тогтоомжуудыг өөрийн байгууллагын цахим хуудсанд тогтмол байршуулж ажиллаад байна. -2024 оны жилийн эцсийн байдлаар хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээлэл тус байгууллагад ирүүлээгүй байна.
3	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах	3.1 Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах	Нийгмийн даатгалын байгууллагын зүгээс иргэд, даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж авагч, ажил олгогч нарт зориулан хүргэж буй 34 төрлийн төрийн үйлчилгээг байцаагч ажилтнууд хуулийн хүрээнд нээлттэй, хүнд сурталгүй, чирэгдэлгүй, хугацаанд нь хүргэн ажиллаж байна. Үүнээс 24 үйлчилгээ нь цахимжаад байна. Тухайлбал: Тэтгэмжийн даатгалын сангаас олгогддог хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, жирэмсэн болон амаржсаны тэтгэмж,

	арга хэмжээ авах		ажилгүйдлийн даатгалын сангаас олгодог ажилгүйдлийн тэтгэмжүүд цахим хэлбэрт шилжээд байна. Байгууллагын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээг http://daatgal.ar.gov.mn/, нийгмийн даатгалын албан ёсны page хуудас, байгууллагын мэдээллийн самбарт ил тод байршуулсан. Мөн www.shilendans.gov.mn Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмыг ажилдаа мөрдлөг болгон ажиллаж www.shilendans.gov.mn, байгууллагын www.ndaatgal.ar.gov.mn мэдээллийн сайтад Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, сангийн болон үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг батлагдсан маягтын дагуу сар, улирал бүр НДСан тус бүрээр нь гаргаж хуулийн хугацаанд нь тогтмол мэдээллэн ажилласан.
		3.2 Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;	АТГ-ын Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтсээс УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024.04.02-ны өдрийн “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах” 5 дугаар тогтоолыг танилцуулах сургалтыг цахимаар ЭБАТ-ны зүгээс газар, сумдын байцаагч нарт “Мэдүүлгийн цахим системийн ашиглалт, ХАСХОМ гаргахад анхаарах асуудал” сэдэвт сургалтуудыг танхимаар тус тус зохион байгууллаа. Дээрх сургалтын үр дүнд мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим сан (http://meduuleg.iaac.mn)-д мэдүүлгээ шинэчлэн гаргасан 21 байцаагчийн “баталгааны маягт”-ыг хэвлүүлэн авч баталгаажуулалтыг хийж, шинээр улсын байцаагчийн эрх авсан, нэр бүхий 4 байцаагчийн ХАСУМ-ийг АТГ-т хянуулан, хуулийн хугацаанд ХОМ-ийг гаргуулан баталгаажуулж ажилласан. Мөн Нийгмийн даатгалын бүтэц шинэчлэгдсэнтэй холбогдуулан шилжүүлэн томилогдсон 2 байцаагчийн ХОМ-ийг гаргуулан баталгаажуулж ажилласан байна.
		3.3 Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх	Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран “Авлига, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сургалтыг аймгийн төвийн байцаагч нарт танхимаар, сумдын байцаагч нар ZOOM- ээр зохион байгуулан харилцан санал солилцон ажиллалаа. Сургалтанд газар, сумдын 38 байцаагчид хамрагдсан. Архангай аймаг дахь Прокурорын газраас “Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгах, дахин гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх” чиглэлээр зохион байгуулсан сургалтанд байгууллагын удирдлага, албан хаагч нар танхимаар, 18 сумдын байцаагч нар цахимаар хамрагдсан байна.

